



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 8/54

Шивээговь сум

Ш.Батмөнхийг жолоочоор томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйл, 48 дугаар зүйлийн 48.1, 50 дугаар зүйлийн 50.1 дэх заалт, Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 192 дугаар “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” тогтоол, Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар “Журам батлах тухай” тогтоолын 1 дүгээр хавсралт “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын 2 дахь заалт, ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Засаг даргын Тамгын газрын жолоочоор Шишкиний Батмөнхийг 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн томилсугай.

2.Ш.Батмөнхөд эд хөрөнгийг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга:

Д.Сэлэнгээ

(Нягтлан бодогч)

Гишүүд:

Д.Отгонбаатар

(Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)


Б.Алтжин

(Нярав)

3.Ш.Батмөнхийн үндсэн цалинг TY-3 зэрэглэлийн 569,585 (таван зуун жаран есөн мянга таван зуун наян тав) төгрөг, Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 20%-иар тус тус үндсэн цалингийн хувиар бодож сар бүр олгохыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ЦЭРЭНДОРЖ



D:\2022 oni barimt\TDarga\tushaal

622220204